

ДУНДАД МОНГОЛЫН СОЁЛЫН НЭВТРЭЛЦЛИЙН СУДАЛГААНЫ МОНГОЛ СУДЛАЛ ДАХЬ БАЙР СУУРЬ ХИЙГЭЭД ТҮҮНИЙ СОЁЛЫН ЗӨРҮҮНИЙ ЗАДЛАЛТ

З.Илаан, профессор
ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургууль

Abstract: This author discusses the role of the research of cultural communication between Mongolia and China plays in the Mongolian studies; secondly analyzes the cultural different between Mongolia and China; thirdly, presents her idea how to smooth the cultural communication between Mongolia and China by new media. Internatioanal of cultural communication the economy, politics, literacy and military specific gravity of the proceedings, but also whether to sign the nation's instrument is a forward and a lot of channels and frequency of access, and at present access to potencies hard to settle weak. Currently economic complex, international intermediaries not probation trends in Mongolian, Middle East and Russia, one of the cross-border life settled ethnic Mongolians in our multi-cultural forces that affect hard as one of the real economic strength communication with measures to improve the qualifications and of intermediaries productive use communication channel, the frequency increases, communication continuous tightening momentum is important. On the other hand the Mongolian border in cultural differences highlight cultural differences, they know the culture jams formed as away of cultural penetrate to rectify the mental perspective should choose.

Түлхүүр үг: Дундад монголын соёлын нэвтрэлцэл, монгол судлал, соёлын зөрүү, монгол үндэстэн, монгол судлал

Удиртгал

Нэг улс үндэстний олон улс дахь соёлын нөлөөлөл нь аж ахуй, улс төр, бичиг эрдэм, цэргийн талаарх өвөрмөц

нөлөөллийн хүрээнд хамаарах төдийгүй тэрхүү улс үндэстний нэвтрэлцлийн арга хэрэглүүрийнх нь урагшилсан эсэх хийгээд нэвтрэлцлийн суваг ба давтамжийнх нь олон цөөнөөр илрэх нэвтрэлцлийн эрчмийнх нь чанга сулаас ч шийдвэрлэгдэнэ. Одоогоор аж ахуй нэг цогцчилж, зуучлуур олон улсжих нь хориглогдошгүй хандаш болсон байдалд Монгол, Дундад, Оросын хил дамнасан амьдрал суурьшилтай угсаа нэгтэй монголчууд маань олон улс дахь соёлын нөлөөлөл хүчнээ чангатгая гэвэл нэг талаар аж ахуйн бодит хүчээ дээшлүүлэхийн хамт нэвтрэлцлийн арга мэргэжлээ дээшлүүлж, шинэ зуучлуурыг бүтээмжтэй ашиглан нэвтрэлцлийн суваг, давтамжаа нэмэгдүүлж, нэвтрэлцлийн эрчмээ тасралтгүй чангаруулах чухалтай. Нөгөө талаар монголчуудын хил дамнасан соёлын нэвтрэлцэл дэх соёлын зөрүүг тодруулж тэдгээр зөрүүнээс бий болж мэдэх соёлын түгжрэлээс зайлуулан адил бус соёлтны нэвтрэлцлийг шулуутгах арга сэтгэцээ хандлагатайгаар сүвэгчлэхийг эрхэмлэвэл зохино.

1. Дундад Монголын соёлын нэвтрэлцлийн судалгааны монгол судлал дахь байр суурь

Дундад Монголын соёлын нэвтрэлцэл бол Дундад, Монгол хоёр улсын хил дамнасан адил бус соёлтны нэвтрэлцлийн судлагдахууны нэг бөгөөд монгол судлалын чухал бүрэлдэхүүн хэсэг болно. Монголчууд XIII зуунаас эхлэн хүчирхэгжин мандаж Ази, Европыг эрхшээсн агуу сундалсан том гүрэн – Монгол Юань Улсыг байгуулсан бахдам түүхтэй бөгөөд өдөөгөө тэдний үр хойчис Дундад, Монгол, Орос гурван улсад тархан амьдарч буй. Уламжлалт монгол бичгээ хэрэглэж байгаа болон хүн амын тоо олон

хийгээд хятад соёлын нөлөөг хүртсэнээрээ Дундад Улсын монголчуудын соёл товойм онцлог шинжтэй гэдэг боловч, Европ соёлын нөлөөг илүүтэй хүртсэн мөртлөө бие даасан тусгай улсын хувиар монгол соёлын өлгий болж ертөнцийн чихнээ алдаршуулан яваагаараа Монгол Улсын соёл баялаг агуулгатай, өвөрмөц онцлогтой байгаа юм. Дэлхийн монголчууд маань гурван улсад таслагдан харьяалагдсан төдийгүй бас халх, ойрад, буриад, цахар, харчин гэхчлэн олон ястанд хуваагдсан бөгөөд тэдгээр нь адил бус цаг үед адил бус байгаль, нийгэм, соёлын орчны нөлөөгөөр түүхийн цаг хугацаа нь харилцан адил бус болсноор барахгүй бас хэл аялгуу, зан заншил, соёл сэтгэц, амьдралын хэлбэр, амьжиргааны байдал тус тус өвөрмөц онцлогтой болов. Иймэрхүү соёлын зөрүү нь өнөөдөр Дундад Монголын улс төр, аж ахуйн нээлттэй, чөлөөтэй төрийн бодлого, шинжлэх ухаан техник мэргэжлийн үсрэнгүй хөгжилт хийгээд зам харилцаа дөрвөн зүг найман зовхист нэвтрэн хурдассан байдалд хилийн шугамын хязгаарлалаасаа илүүтэйгээр соёлын нэвтрэлцэлд харш саад учруулж буй. Адил бус соёлын харилцаа нэвтрэлцлийн урьтал нөхцөл бол олон соёлын хамтаар орших явдал болно. Даруй адил бус соёлтны нэвтрэлцлийн тус бие нь нийтлэг шинж ба өвөрмөц шинжийг зэргээр чангатгаж, адил бус соёлын орчин дахь хүмүүсийн соёл нь зөрүүтэй боловч нэвтрэлцэл нь харш саадгүй байхыг сурталчилна. Ер нь хүн төрөлхтөнд ялгаа зөрүү байж гэмээ нь сая нэвтрэлцэх хэрэгцээ гардаг. Соёл, угсаа зүйн байдлаас ажиглахад Төв Азид нутагтай Дундад, Монголын монголчууд улсын харьяалал, соёлын нөлөөллийн байдлаараа харилцан адилгүй байдгаас Дундад, Монголын соёлын нэвтрэлцлийг гурван давхаргын адил бус соёлтны нэвтрэлцэлд хуваан судалж шинжилж болно. Улсын давхаргад Дундад Улс ба Монгол Улсын хил дамнасан соёлын нэвтрэлцэл, үндэстний давхаргад монгол ба хятад, монгол ба манж, монгол ба хотон гэхчлэн монгол үндэстэн ба бусад үндэстэний соёлын нэвтрэлцэл; Ястны давхаргад халх ба цахар, хорчин ба буриад, үзэмчин ба ойрад гэхчлэн адил бус ястнуудын Дундад, Монгол хоёр улс дахь соёлын нэвтрэлцлийн байдлыг багтаана. Ялангуяа Дундад Улс 1978 оноос өөрчлөлт шинэчлэлтийн замаар замнаж, Монгол Улс 1990 оноос ардчилсан

засаглалыг хэрэгжүүлсний дараа Дундад, Монголд байгаа ястнууд нийгмийн адил бус соёл хийгээд байгалийн өөр өөр ахуй орчноос болж амьдралын арга хэлбэр нь зөрүүтэй хөгжсөнөөс соёлын нэвтрэлцэлд нь саад тотгор бий болжээ. Нэвтрэлцлийн байдлаас ажиглавал Монгол, Дундад хоёр улсын монголчуудын харилцааны нэвтрэлцэл, хамтлагийн нэвтрэлцэл, зохион байгуулалтын нэвтрэлцэл, олон нийтийн нэвтрэлцэл гэх дөрвөн төрлийн нэвтрэлцлийн арга хэрэглүүр нь ерөнхийдөө шинэ харилцааны хэлбэрт шилжиж байгаагаараа адилхан. Гэвч хоёр гүрэн дэх монголчуудын соёлын нэвтрэлцэлд холбогдох дохио тэмдгийн тогтолцоо, өртгийн үзэлтийн хөөцөлдөл хийгээд хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн хамааралтын арга авцал нь өдий төдий талаар ондоошсон үзэгдэл зөндөө буй. Эдгээр ондоошсон үзэгдлүүдийг харилцаа нэвтрэлцлийн орчинд нь аваачин судалж тодруулах нь даруй Дундад Монголын соёлын нэвтрэлцлийг шулуутгахад зориулсан адил бус соёлтны нэвтрэлцлийн судалгааны чухал агуулга болно.

Дундад Монголын соёлын нэвтрэлцлийн судалгаа бол монгол судлалд онцын чухал байр суурьтай судалгаа шинжилгээний салбар юм. Монгол Улс тусгаар улсын хувиар монголчуудыг даян дэлхийд дээдэлж яваа бөгөөд олон улсын Монгол судлалын төв ч Монгол Улсад байна гэхэд, Дундад Улсын монголчуудын хүн амын тоо олон бөгөөд уламжлалт монгол бичгээрээ монгол соёлоо дэлхий нийтийн сонорт босоогоор нь таниулж байна. Иймээрээ монгол судлалд эртнээс одоо болтол монголчуудын түүх соёлын аль нэг асуудлыг задалж тодруулъя гэвэл Дундад, Монголын монголчуудын аль нэг талын байдлыг ганц талаас өрөөсгөлөөр баримталж огт боломгүй байж, аль алиных нь түүх соёл, үйлдвэрлэл амьдралынх нь бодит байдалд гүнзгийрсэн судалгаа хийх шаардлагатай юм. Орчин тойрон хүнийг бүтээдэг гэдэгчлэн Чингисийн үеийн нэгдмэл монголчууд маань сүүлийн үед Монгол, Орос, Дундад гэх гурван улсад хуваагдан амьдарсан бөгөөд учир явдлыг бодож сэтгэх, болгоож тунгаах арга сэтгэц нь харилцан адил бус болсон нь соёлын нэвтрэлцлийн адил бус орчноос шалтгаалагдсан үзэгдэл юм. Энэ нь монгол соёлын олон эсчлэх чиглэлээр хөгжихөд



ашигтай боловч, хоорондоо нэвтрэлцэхэд хичээхгүй бол эндүү ойлголцож, хоорондох нэвтрэлцэлд нь харш саад учрах тохиолдол үргэлж гарах болгожээ.

II. Дундад Монголын соёлын нэвтрэлцэл дэх соёлын зөрүүний задлалт

Хүн төрөлхтний соёлын хөгжилтийн явцад ямарваа соёлтон хэрэв өөр соёлтон лугаа харьцуулахгүй, нэвтрэлцэхгүй юм бол өөрсдийн соёлын хөгжсөн эсэх хийгээд хөгжилтийн хурдан удаанаа мэдэхийн аргагүй юм. Гэхдээ хаа адил бус соёлтны нэвтрэлцлийн ажиллагаа явагдвал тэнд соёлын зөрүү мэдрэгддэг. Өөрөөр хэлбэл нийгмийн орчныг хувь хүн өөрчилж чаддаггүйтэй адилаар адил бус соёлтны нэвтрэлцэл дэх соёлын зөрүү бол үгүйсгэж болшгүй бусад чи (биет бус) оршихуй юм. Энэхүү соёлын зөрүүг ялан давах чадварыг хүмүүжүүлж болох бөгөөд иймэрхүү адил бус соёлтон лугаа харилцах хэлний чадвар, харилцааны чадвар хийгээд зохицолдох чадварыг хүмүүжүүлж дээшлүүлэх бол даруй адил бус соёлтны нэвтрэлцлийн ухааны үүрэг хариуцлага болно. Соёлын зөрүүг системтэй тодруулахад бодисын соёл, оюуны соёл, дүрмийн соёл хийгээд үйл ажиллагааны соёл зэргийг хамруулах хэрэгтэй боловч, энд зөвхөн асуудал дэлгэх зорилгоор Дундад, Монголын монголчуудын соёлын нэвтрэлцэлд үргэлж тохиолддог соёлын зөрүүнээс жишээлэн дурдсан төдий юм.

Нэгд, хэл аялгуу хийгээд нэр нэрийдлийн зөрүү. Үг хэл бол хүн төрөлхтний нэвтрэлцлийн хамгийн анхдагч бөгөөд хамгийн үндсэн зуучлуур юм. Учир нь аливаа зуучлуур бүр хэлээр дамжуулан мэдээллийг дамжуулж сэтгэлгээг илэрхийлдэг. Дундад, Монголын монголчууд хэдийгээр адилхан монгол хэлээрээ харилцдаг гэдэг боловч, дэлгэрүүлж байгаа баримжаа авиа ба хэрэглэж байгаа нэр томъёо нь хоорондоо өдий төдий зөрүүтэй байдаг. Иймэрхүү хэлний хэрэглээний зөрүүтэй байдал нь Дундад, Монголын соёл шинжлэх ухааны нэвтрэлцлийн хамгийн анхны саад болж буй асуудал болно. Иймээс Дундад Монголын соёлын нэвтрэлцлийг шулуутгахад юуны өмнө монголчуудын эл угсаатан ястны одоогийн хэл аялгууны байдлыг ойлгож, харилцаа нэвтрэлцлийн үйл ажиллагаанд

хэрэглэгдэх ялгаа зөрүүг нь харьцуулан тодруулж харилцагчийнхаа хэл аялгууны онцлогт зохицуулан тэр нутгийн авиа дуудлага, үг хэллэг хийгээд нэр томъёог боловсронгуй хэрэглэж сурах нь адил бус соёлтны нэвтрэлцлийн үйлдвэрлэгчид хийгээд судлаачдын хамгийн түрүүнд биелүүлэх чухалтай соёлын зохицолтын ажиллагаа болно.

Хоёрт, үсэг бичиг хийгээд бичлэгийн хэвишийн зөрүү. Хүн төрөлхтний нэвтрэлцлийн түүхэнд үсэг бичигтэй болсноор цээжлэлдээ түшиглэн ярианы хэлээр уламжлагдан дамжуулагдсан хувилбар ихтэй мэдээлэл нь үсгийн дохионд кодлогдон орон зай хийгээд цаг хугацаанд хязгаарлагдалгүйгээр дамжуулагдах оновчтой мэдээлэл болж хүн төрөлхтний соёлыг боловсны үед татан оруулжээ. Ойр үеийн хэсэглэл тусгаарлал хийгээд шинэ соёлын орчинд Дундад Улсын монголчууд уламжлалт босоо монгол бичгээ үргэлжлэн хэрэглэхийг баримталсан байхад, Монгол Улсын монголчууд 1946 оноос кирилл үсгийг хэрэглэх болсноос Дундад, Монгол хоёр улсын монголчууд адилхан хэлтэй байтлаа мэдлэг мэдээлэл, үзэл бодлоо илэрхийлэх үсэг бичиг нь адил бус болсноос хоёр улсын монголчуудын соёлын нэвтрэлцэлд бага бусын харш саадыг буй болгожээ. Монгол Улсын монголчууд кирилл үсгийг авч хэрэглэсэн төдийгүй он жил цаг хугацааг монгол тоогоор тэмдэглэн илэрхийлдэг бөгөөд үргэлж хэрэглэгдэх улс гүрэн, байгууламжийн нэр мэтийн оноосон нэрийг товчлон бичдэг нь Дундад, Монголын монголчуудын хоорондох бичгийн хэлний нэвтрэлцлийн харш саадыг улам нэмэгдүүлжээ.

Гуравт, нэвтрэлцлийн арга сэтгэцийн зөрүү. Дундад, Монголын монголчуудын нийгэм, соёлын орчин нь адил бусаас болж зүс царайны гоёлолын ухамсар, хүндэтгэлээ илэрхийлэх арга хэлбэр, цагийн ойлголт хийгээд орны ашиглалтын талаар тус бүр адил бус ойлголттой болжээ. Үүнд Монгол Улсын монголчууд европ соёлын нөлөөг арай илүү хүртсэнээс болов уу, олон нийтийн харилцаанд царай зүсээ гоёлох ба хувцас заслаа цэвэр дүрэмжилтэй байлгахаа бусдыг хүндэтгэж байхын нэг арга хэлбэрээр үзээд гоёлож чимэглэхийг эрх үүрэг гэж ойлгон засал гоёлолоо илт мэдэгдэм байлгахыг илүүтэй хөөцөлддөг

байхад, Дундадын монголчууд нүүр зүсээ гоёлох сайхан хувцас өмсөхийг өөрсдийн эрх байрын илэрхийлэлтээр ойлгодог нь арай илүү байдгаас гоёл зассанаа аль чадахаараа мэдэгдэмгүй байлгахыг эрхэмлэн хөөцөлддөг.

III. Дундад Монголын монголчуудын соёлын нэвтрэлцлийг шулуутгахад шинэ зуучлуурыг ашиглах арга сэтгэц

Уул нь газар зүйн байршил хийгээд улс гүрний харьяалагдал бол хүмүүсийн харилцаа нэвтрэлцлийн хамгийн чухал нөхцөл болж байсан бол, шинэ зуучлуурын орчинд нэг гэрт орогнож байсан ч өөр өөрийн гар утсаа барьж амьд бус харилцааг үүсгэж хажуу хавийн хүмүүстэйгээ тийм нягт харилцаатай биш боловч, алс газрын адил бус соёлтонтой адил цагт сүлжээгээр нягт харилцан нэн дотносог харилцаатай болж бие хол ч сэтгэл ойр нэвтрэлцлийн давтамж өндөр байх явдал зөндөө болжээ.

Дундад Монголын монголчуудын соёлын нэвтрэлцэл дэх шинэ зуучлуурын үйлдэл чадамжийг гүйцэд бадруулах бол урт удаан хугацааны будлиантай үйлдлэг туршилтын явц байж таарна.

Юуны өмнө мэдээлэл боловсруулалт хийгээд шинэ зуучлуураар тухайлсан ажлаа болгосон шинэ зуучлуурт монгол үг хэл, үсэг бичгийг цаг тухайд нь кодлон таниулж, шинэ зуучлуурын монгол соёлын нэвтрэлцэл дэх чадамж үйлдлийг тасралтгүй төгөлдөржүүлэн дээшлүүлэх бол монголчуудын адил бус соёлтны нэвтрэлцлийн үйл ажиллагааны үр бүтээмжээ дээшлүүлэхийн зангилгын асуудал болно. Дараа нь төрийн бодлогын дэмжлэгийн хүчилцээ нэмэгдүүлж шинэ зуучлуураар тухайлсан ажил мэргэжлээ болгогсдын хамааралтаа чангатгаж, “Манай улсын тоожуулсан хэвлэлийн аж үйлсийн хөгжилтийг түргэтгэх тухай саналаа (关于加快我国数字出版产业发展的若干意见) цөөн тоот үндэстний сонин мэдээлэл нэвтрэлцлийн үйлсэд хэрхэн хэрэгжүүлэх хүртэл бодитойжуулан тодруулж эл үндэстний соёлын нэвтрэлцлийг шулуутгах ажиллагаанд туушлуулан хэрэгжүүлбэл зохино.

Гуравт, адил бус соёлтны нэвтрэлцэл дэх шинэ зуучлуурын чадамж үйлдлийг төгөлдөржүүлэхдээ зөвхөн хэлбэр сувгийн

түвшинд төдий биш, харин олон эшчилсэн соёлын агуулгаар баялагжуулахыг чухалчилж, дэлхийн монголчуудын баялаг шилдэг өв соёлын эх баялгийг уудалж шинэ зуучлууруудын тус бүрийн онцлогт тохиролцуулан шинэ технологиор тэмдэглэн тодруулж дамжуулан уламжлахыг цаг ямагт хичээвэл зохино.

Дөрөвт, нэвтрэлцлийн арга сэтгэцээ цаг тутам төгөлдөржүүлэн сайжруулж, хандлагат соёлтныхоо хүлээн авч ойлгон тогтооход тохиромжтой цаг хугацаа ба дохио тэмдэгт шинэ зуучлуурыг сонгон хэрэглэхийг анхаарвал зохино. Жишээлбэл, Дундад Улсын Монголд зориулагдсан “Солонго” дэлгэцэнд кирилл үсэг ба уламжлалт монгол бичгээ зэргээр тодруулж, нэвтрүүлэх цагийн хувьд үдэд биш, харин орой хорин цагаас хойш байлгавал Монгол Улсын монголчуудын өдөржин малаа адуулж гэрийн бараа хардаггүй, зөвхөн орой шөнөөр сая сул сэлүү цагтай болж, телевиз үздэг хүлээн авах дадалд нь илүү тохиромжтой болгоно.

Тавд, шинэ зуучлуурын буй болж хэрэглэгдсэнээр уламжлалт зуучлуурын үйлдлийг яасан ч омтгойлж болохгүй. Учир нь нэвтрэлцлийн арга хэрэглүүр гэж зохих утгаас хэлбэл, шинэ хуучин зуучлуурыг бүтэмжтэй уялдуулахыг зааж буй юм. Жишээлбэл, үсэг бичгийн зуучлуур буй болсноос үг хэлний зуучлуур устдаггүй жимээр сүлжээ, гар утасны мэргэжилд тулгуурласан шинэ зуучлуурын буй болсноор ном, сонин, сэтгүүл, радио, кино, телевиз зэрэг уламжлалт зуучлуур бүрмөсөн устдаггүй юм. Монгол, Дундадын монголчуудын одоогийн зуучлуур хэрэглэж байгаа бодит байдал гэвэл шинэ зуучлуурыг хэрэглэж эхэлсэн боловч, хэрэглэлтийн тархац нь тийм өргөн дэлгэр биш байж, нэн өргөн тархацтай хөдөө тосгоны монголчууд бас л ном бичиг, сонин сэтгүүл, радио телевиз зэрэг уламжлалт зуучлуурт түшиглэн соёл урлаг, сонин мэдээллээ хүлээн авч байна. Иймээс Дундад Монголын монголчуудын соёлын нэвтрэлцлийг шулуутгахад нэг талаар уламжлалт зуучлуурын дохио тэмдгийн бусад машин мэргэжилд түшиглэхгүй харьцангуй тусгаарлангуй шинжийг шинэ зуучлуураар орлуулахын аргагүй юм. Нөгөө талаар шинэ зуучлуураар нэвтрэлцэхэд машин мэргэжилд хязгаарлагдах төдийгүй, агуулгынх нь найдварт бус эсвэл эрх сүрт



бус шинж хийгээд уламжлалт зуучлуурт түшиглэсэн шинж зэрэг дутагдалтай. Үүнд, Монгол Дундадын монголчуудын соёлын нэвтрэлцэлд хамгийн их харш саад болсон кирилл үсгээр тэмдэглэгдсэн зохиол бүтээлийг монгол бичигт буулган хэвлэх ажил одоо маш эрчимтэй хийгдэж байгааг дурдууштай юм. Зургадугаарт, Монгол Дундадын монголчуудын соёлын нэвтрэлцлийг харилцааны нэвтрэлцэлд суурилуулахыг хичээвэл зохино. Өөрчлөлт, нээлт, шинэчлэл, хамтралцлаар хамтын онцлогоо болгосон шинэ зуучлуурын орчин дахь адил бус соёлтны нэвтрэлцэл бол харилцааны нэвтрэлцэл, хамтлагийн нэвтрэлцэл, зохион байгуулалтын нэвтрэлцэл хийгээд олон нийтийн нэвтрэлцэл мэт олон давхаргын харилцаан дахь зуучлуурын хэлбэрийг хамтатгасан тул өвөрмөц шинжийг чухалчилсан, хүнчилсэн нэвтрэлцлийн арга хэлбэрийг чухалчилдаг. Үг хэл бол хүн төрөлхтний аливаа нэвтрэлцлийн дохионы суурь нь байдагчлан, харилцааны нэвтрэлцэл бол хүн төрөлхтний аливаа давхаргын нэвтрэлцлийн суурь чулуу юм. Энэ нь яг компьютер хэл шинжлэлд уламжлалт хэл бичгийн ухаан нь үндэс суурь нь болж, хүн өөрсдөө таньж тайлбарлаж чадсангүй хэлний мэдлэгийг компьютерт яасан ч таниулж чаддаггүй байдагтай адилаар Дундад, Монгол хоёр улсын монголчуудын хоорондох харилцааны нэвтрэлцэл байхгүйгээр өвөрмөцжүүлсэн шинжтэй шинэ зуучлуураар хэнтэйгээ гэж нэвтрэлцэнэ билээ. Тухайлбал, сүлжээний зоог (BBS QQ), гар утасны мессаже зэрэг харилцааны зуучлуур нь нэвтрэлцүүлэгчийн зорилгоо тодруулан чангатгахад ашигтай гэхэд электрон хэвлэл, сүлжээний хайлт хийгээд бусад хээрийн байцаалт хийгсэд лугаа туршлага солилцох зэргээр харилцагчийн мэдлэгийг нэмэгдүүлдэг бол MP3, DVD мэтийн тоожуулсан зуучлуураар харилцагчийн нэвтрэлцлийн ур дэмийг баялагжуулан адил бус соёлтны нэвтрэлцлийг түгээмэлжүүлэхэд ашигтай юм. Долдугаарт, Дундад Монголын монголчуудын соёлын нэвтрэлцэлд тусгай мэргэжилтний сургуулийн сурган хүмүүжил хийгээд ажлын байран дахь мэргэжил дээшлүүлэлтийг уялдуулахыг чангатгавал зохино.

ДҮГНЭЛТ

Сургуулийн сурган хүмүүжил, тухайлсан ажлынхан хийгээд эрдэм шинжилгээнийхэн тоожуулсан шинэ зуучлуурын мэргэжил, адил бус соёлтны нэвтрэлцлийн ур дэм, монгол соёлын баялаг мэдлэг бүхий нийлэг чадвартныг хүмүүжүүлэхэд хамтран ажиллахыг хүндэтгэн чухалчилбал зохино. Үүнд Дундад, Монголын сургуулийн сурган хүмүүжилд оюутан, аспирантыг харилцан томилон суралцуулах, эрдэм шинжилгээний ном өгүүллийг хооронд нь хөрвүүлэн буулгах, хэвлэл мэдээллийнхэн тусгай суваг программыг олон бэлтгэн үйлдэж, Дундад, Монгол хоёр улсын монголчуудын хоорондох соёлын нэвтрэлцэлд гүүр холбоосын үйлдлийг үзүүлсээр байгаа боловч цахим сүлжээ зэрэг шинэ зуучлуурыг хоёр улсын түвшинд нийтэд ашиглуулах талаар нэн бодитой бодлого төсөл гаргаж хамтран ажиллах арга замыг сүвэгчлүүштэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- 《关于加快我国数字出版产业发展的若干意见》, <http://www.gou.cn/gongbao/content/2011/content-1778072.htm>
- [加拿大] 马歇尔·麦克卢汉:《理解媒介:论人的延伸》, 何道宽译, 商务印书馆, 2000年10月.
- [美保罗]·莱文森:《新新媒介》(第二版), 何道宽译, 复旦大学出版社, 2014年7月.
- 第四媒介, <http://baike.so.com/doc/7128021.html>
- 关于第五媒体 <http://baike.so.com/doc/7128021.html>
- [英尼克]·库尔德利:《媒介, 社会与世界: 社会理论与数字媒介实践》, 何道宽译, 复旦大学出版社, 2014年5月.
- 安德烈·冈德·弗兰克: 巴里·K. 吉尔斯主编: <<世界体系: 500年还是5000年? >>, 郝名玮 译, 社会科学文献出版社, 2004年1月
- 《关于加快我国数字出版产业发展的若干意见》, <http://www.gou.cn/gongbao/content/2011/content-1778072.htm>